



ГОВЬСҮМБЭР АЙМАГ  
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 01 сарын 06 өдөр

Дугаар А/02

Шивээговь сум

Иргэний баримт бичгийн үзлэг  
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Иргэний улсын бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2, Монгол Улсын нутаг дэвсгэрт иргэн шилжин суурьших хөдөлгөөнийг бүртгэх, мэдээлэх журмын 2.1 дэх заалт, аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/412 дугаар “Иргэний баримт бичгийн үзлэг зохион байгуулах тухай” захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Иргэний баримт бичиг, шилжилт хөдөлгөөний хаягийн бүртгэлийг цэгцлэх, үзлэг явуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай.

Комиссын дарга:

Ч.Сугармаа

(Засаг даргын орлогч)

Нарийн бичгийн дарга:

Л.Алдар

(Улсын бүртгэгч)

Гишүүд:

А.Нандинцэцэг

(1 дүгээр багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

А.Энхмаа

(2 дугаар багийн Засаг даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Шинэбаяр

(Цагдаагийн хэсгийн дарга, цагдаагийн хошууч)

Б.Мөнхцэцэг


(Нийгмийн даатгалын байцаагч)

421210005

2. Иргэний баримт бичиг, шилжилт хөдөлгөөн, хаягийн бүртгэлийг цэгцлэх ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэхийг бүх байгууллагын дарга, эрхлэгч нарт даалгасугай.

3. Үзлэгийг 2021 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс 03 дугаар сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг ажлын хэсгийн дарга /Ч.Сугармаа/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



П.ГАНЧИМЭГ